Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ДЭЛГЭРЭХ ДЭНЖИЙН 7 ДУГААР БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ А.НОРОВСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. “Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг анхан шатанд хэрэгжүүлж, иргэд олон нийтэд сурталчлан ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1.1.1 | Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүйн сургалт, зөвлөгөө өгөх (АБТодорхойлолт 1.1 дэх заалт) *(АБТодорхойлолт 1.1 дэх заалт) “Нийгмийн даатгалын тухай хууль”,* | Зөвлөгөө, мэдээлэл өгсөн хүний тоогоор | 400 | 800 | 2024 оны байдлаар халамжийн үйлчилгээ авсан 124 иргэнд Нийгмийн халамжийн тухай хуулийн тодорхой зүйл заалтуудаар, улсын бүртгэлийн үйлчилгээ авсан 34 иргэнд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн тодорхой зүйл заалтуудаар, цагдаа, шүүхийн үйлчилгээ авсан 72 иргэнд Зөрчлийн тухай хууль болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зүйл заалтуудаар, газар олгохтой холбоотой үйлчилгээ авсан 10 иргэнд Газрын ерөнхий хуулийн зүйл заалтуудаар тус тус зөвлөгөө мэдээлэл олгосон.<br>2024.06.05-ны өдөр зохион байгуулсан Авлигын эсрэг өдөрлөгийн үеэр Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар болон цахим | 1- 11 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *"Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хууль"* | | | | халдлагаас сэргийлэх тухай зөвлөгөө мэдээлэл олгож нийт 120 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.<br>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын 2 дугаар бүлгийн "Нийгмийн даатгалын сан"-ийн тухай ойлголтоор багийн ахмадын өдөрлөгийн үеэр сургалт зохион байгуулж 92 ахмадад, багийн иргэдийн Нийтийн хурлын үеэр "Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн тухай" 131 иргэнд тус тус мэдээлэл олгосон.<br>2024 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаар танилцуулга хийж 45 цэргийн насны залуучуудад мэдээлэл өгсөн. Танхимын 3 удаагийн сургалтаар Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаар 83 иргэнд мэдээлэл хүргэсэн.<br>Түүнчлэн Эмтийн 2 дугаар багийн нийгмийн ажилтантай хамтран Арвайхээр сумын Мэргэд, Тэмүүлэл-Эрдэм, 5 дугаар сургуулийн орчинд Хүүхэд хамгааллын тухай хууль, СУЭХТАСТТ хууль, what3words, e-kids аппликейшны талаар 110 орчим иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн.<br>Өвөрхангай аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан иргэдэд хууль эрхзүйн зөвлөгөө олгох сургалтад 10 хэсгийн ахлагчийг хамруулсан.<br>Нийт хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл олгосон иргэний тоо 831. | | |
| | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх | 2 | 4 | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулгаар 2 удаа, Согтууруулах ундааны эргэлтэд | 1- 11 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан тоогоор | | | хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн танилцуулгаар 3 удаа, сургалт зохион байгуулсан.<br>Нийт зохион байгуулсан сургалтын too 5. | | |
| | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2 нэр төрлийн хуулийн сургалт сурталчилгаа, гарын авлага бэлтгэн боловсруулсан тоогоор | 2-оос доошгүй материал бэлтгэж, 250-аас доошгүй иргэнд түгээсэн байна | 4-өөс доошгүй материал бэлтгэж, 500-аас доошгүй иргэнд түгээсэн байна | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 20, 28 дугаар зүйл болон согтууруулах ундааны хэрэглээнээс үүдэлтэй гэмт хэрэг зөрчлийн мэдээллийн талаар агуулсан 1 гарын авлага бэлтгэж 3 удаагийн танхимын сургалтын үеэр 97 ширхэг, цэрэг татлагын үеэр 55 ширхэг, Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй аяны үеэр 50 ширхэг, Явуулын үйлчилгээний үеэр 40 ширхэг, хагас жилийн мал тооллогын үеэр 20 ширхэг, "Авилгыг тэвчье, сэргийлье" өдөрлөгийн үеэр 50 ширхгийг тус тус тараасан. Нийт тараасан гарын авлагын тоо 312.<br>Мөн Зөрчлийн тухай хуулийн 3, 4 дүгээр бүлгийн агуулгаар гарын авлага бэлтгэж, Явуулын үйлчилгээ үйл ажиллагааны үеэр 40 ширхэг, "Авилгыг тэвчье, сэргийлье" өдөрлөгийн үеэр 20, Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй аяны үеэр 20, 3 удаагийн танхимын сургалтын үеэр 97 ширхгийг тус тус тараасан. Нийт тараасан гарын авлагын тоо 177.<br>Монгол улсын "Замын хөдөлгөөний дүрэм"-ийн 5, 6 дугаар бүлгийн агуулгаар гарын авлага бэлтгэн танхимын сургалтын үеэр 45 ширхгийг тараасан. Нийт тараасан гарын авлагын тоо 45. | 1- 11 сард | 100 |

141

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Цахим халдлагаас сэргийлэх тухай мэдээллээр 1 гарын авлага бэлтгэн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сурагчдад зохион байгуулсан 2 удаагийн сургалтын үеэр 60 ширхгийг тараасан.<br>Хууль эрхзүйн сургалт сурталчилгааны чиглэлээр бэлтгэсэн гарын авлагын төрөл 4, нийт тараасан гарын авлагын тоо 594. | | |
| 1.1.2 | Багийн иргэдийн Нийтийн хурлын бэлтгэл ажлыг хангах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх (АБТодорхойлолт 1.3 дахь заалт) | Холбогдох хууль тогтоомжийн дагуу хурлын бэлтгэл ажлыг хангасан хувиар | 100 | 100 | БИНХурлын I, II улирлын бэлтгэл ажлыг хангаж хурал зохион байгуулах тухай зар мэдээллийг хэсгийн ахлагч нараар болон цахим сүлжээгээр дамжуулан хүргэж 2 хурлын ирцийг бүрэн хангасан.<br>БИНХурлын I улирлын хурлыг 2024.03.30-ны өдөр зохион байгуулж, хурлаас гарах 3 тогтоолын төсөл, хурлын дэг болон журам (тус бүр 1 хуудас), ирцийн бүртгэлийн маягт, компьютер, дуу өсгөгч, микрафон зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжүүд, сандал, ширээ зэргийг бүрэн бэлтгэж хурлын бэлтгэл ажлыг 100 хувь хангасан.<br>II улирлын хурлыг 2024.05.28-ны өдөр зохион байгуулж орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар багт хийгдэх ажлын саналын урьдчилсан жагсаалт (1 хуудас), хурлын дэг, журам (тус бүр 1 хуудас), хурлын хэлэлцэх асуудал (1 хуудас), хурлаас гарах тогтоолуудын 5 төсөл, компьютер, дуу өсгөгч, микрафон зэрэг хуралд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг бэлтгэн хурлын бэлтгэл ажлыг 100 хувь хангасан. | 1- 6 сард | 100 |
| | | Хуралд оролцсон | 20-оос доошгүй хувь | 25-аас доошгүй хувь | I улирлын БИНХуралд 131 иргэн оролцсоноос 19-39 насны 31 иргэн буюу 23.6 хувь нь залуучууд байсан. | 1- 6 сард | 97.2 |

142

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | залуучуудын хувиар | | | II улирлын БИНХуралд 127 иргэн оролцсоноос 19-39 насны 36 иргэн буюу 28.3 хувь нь залуучууд байсан. | | |
| 1.1.3 | Багийн иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэл, тогтоол шийдвэрийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтлөх (АБТодорхойлолт 1.4 дэх заалт) | Хурлаас гарсан тэмдэглэл, тогтоол шийдвэрийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулсан хувиар | 100 | 100 | 2024 оны I улирлын БИНХурлаас гарсан хурал товлон зарлах тухай 1, хуралдааны дарга сонгох тухай 1, хуралдаан даргалагчид урамшуулал олгох тухай 1 тогтоол, Зөвлөлийн хурлын тэмдэглэл, иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэл, иргэдээс гарсан санал, хурлын дэг, журам, хуралд оролцогчдын ирцийн бүртгэл зэрэг 23 хуудас материалууд,<br>2024 оны II улирлын БИНХурлаас гарсан хурал товлон зарлах тухай 1, хуралдааны дарга сонгох тухай 1, хуралдаан даргалагчид урамшуулал олгох тухай 1, тооллогын комисс байгуулах тухай 1, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар багт хийгдэх ажлын саналыг эрэмбэлсэн тухай 1 тогтоол, Зөвлөлийн хурлын тэмдэглэл, иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэл, ирцийн бүртгэл, тогтоолын хавсралт 1 маягт буюу эрэмбэлсэн саналын жагсаалт зэрэг 18 хуудас материалуудыг тус тус албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж, бүрдлийг бүрэн бүрдүүлж хуульд заасан хугацаанд нь сумын ИТХурлын ажлын албанд хүлээлгэн өгсөн. | 1- 6 сард | 100 |
| 1.1.4 | Арвайхээр сумын 2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, | Багийн сонгуулийн насны нийт иргэдээс саналын хуудсаар санал өгсөн иргэдийн хувиар | 10 | 15-аас доошгүй хувь | Багт сонгуулийн насны 1526 иргэн бүртгэлтэй бөгөөд 2025 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар багт хийгдэх ажлын саналд саналын хуудсаар 216 иргэн санал өгсөн. Энэ нь сонгуулийн насны иргэдийн 14 хувийг эзэлнэ. | 2 - 6 сард | 94 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр, төсөл, арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулах | Багийн сонгуулийн насны нийт иргэдээс цахимаар санал өгсөн иргэдийн хувиар | - | 25-аас доошгүй хувь | 2025 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар багт хийгдэх ажлын саналыг 31 иргэн цахимаар өгсөн. Энэ нь сонгуулийн насны 1526 иргэний 0.02 хувийг эзэлнэ. | 2- 6 сард | 0 |
| | | ОНХС-ын төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын дагуу боловсруулж, ХЗА-д хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн хувиар | 100 | 100 | ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний саналын 1-7 дугаар хавсралт маягтуудын бүрдлийг бүрэн хангаж, багийн Засаг даргын албан тоот, багийн иргэдийн Нийтийн хурлаас гарсан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар багт хийгдэх ажлын саналыг эрэмбэлсэн тухай тогтоолын хамт ХЗА-нд хүлээлгэн өгсөн. | 6 сард | 100 |
| 1.1.5 | **Арга хэмжээ 1.5.** Хэсгийн ахлагчдын ажлын тайлан, мэдээг сар бүр хүлээн авч, улирал бүрээр нэгтгэн сумын ЗДТГазарт хүргүүлэх | Хүргүүлсэн тайлангийн тоогоор | 4 | 4 | Багийн 15 хэсгийн ахлагчийн сарын ажлын тайланг сар бүрийн 20-ны өдөр хүлээн авч нэгтгэн I улирлын тайланг 2024.03.25-ны өдөр, II улирлын тайланг 2024.06.12-ны өдөр, III улирлын тайланг 2024.09.25-ны өдөр, IV улирлын тайланг 2024.11.11-ний өдөр тус тус гарган сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн. | 1- 12 сард | 100 |
| 1.1.6 | **Арга хэмжээ 1.6.** Багийн хэмжээнд цэргийн бүртгэлийг зохион | Бүртгэлд хамрагдсан хувиар | 100 | 100 | 2024 оны цэргийн бүртгэлээр I үүрэгтний бэлтгэл офицер 7, бэлтгэл ахлагч 1, бэлтгэл байлдагч түрүүч 136, нийт 144 иргэн бүртгэгдсэн. | 1 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх *(АБТодорхойлолт 1.4 дэх заалт)* | | | | II үүрэгтний цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасан 15, дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан 11, цэргийн алба хаагаагүй 310, нийт 336 иргэн бүртгэгдсэн.<br>Эдгээр цэргийн бүртгэлд хамрагдах насны 480 иргэнээс 418 биеэр ирж, 62 иргэн цахимаар бүртгүүлсэн байна. Цэргийн бүртгэлд хамрагдалт 100 хувь.<br>Мөн төрийн тусгай албан хаагч 28, цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэй 2, Тайван цагт цэргийн албанд үл тэнцэх 22 иргэн бүртгэгдсэн. | | |
| | | Хүргүүлсэн судалгаа, тайлангийн хувиар | 100 | 100 | Цэргийн бүртгэл хийсэн тухай судалгааг I, II үүрэгтэн, тайван цагт цэргийн албанд үл тэнцэгч, байлдагч түрүүч, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний нэгтгэл, статистик, нөөц, боломж, идэрчүүд, эрчүүдийн нэгдсэн судалгаа, буу, акт морь, техник зэрэг 13 үзүүлэлтээр гаргаж сумын Засаг даргын Тамгын газрын хууль эрхзүйн хариуцсан мэргэжилтэнд өгсөн.<br>Мөн нэгдүгээр үүрэгтний 144 иргэний чанар байдлын судалгааг 10 үзүүлэлтээр гаргаж, аймгийн Цэргийн штабын тоо бүртгэлийн офицерт хүлээлгэн өгсөн. | 1 сард | 100 |
| 1.1.7 | **Арга хэмжээ 1.7.** Сумын дайчилгааны төлөвлөгөө, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, орон нутгийн цэргийн отрядын хүн, техникийн оногдуулалтыг | Төлөвлөгөөний дагуу оногдуулалт хийсэн хувиар | 100 | 100 | Сумын дайчилгааны төлөвлөгөөний дагуу 2024 оны орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, орон нутгийн цэргийн отрядын хүн, техникийн оногдуулалтыг 13 багийн зохион байгуулагч нар 2024 оны 2 дугаар сард хийж гүйцэтгэсэн. 2024 онд бэлтгэл үүрэгтний дадлага сургуулилт зохион байгуулаагүй. Сумын дайчилгааны төлөвлөгөөний оногдуулалтад орсон хүн, техникийн мэдээлэл нь цэргийн нууцах хамаарах тул багийн ажлын албанд | 1- 2 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж бэлтгэл үүрэгтний бэлэн байдлыг хангах | | | | дэлгэрэнгүй судалгаа, мэдээлэл хадгалагдаагүй. Оногдуулалтын ажлын хугацаанд нь бүрэн хийж, холбогдох материалыг Өвөрхангай аймгийн цэргийн штабд хүлээлгэн өгсөн. | | |
| | | Гаргасан судалгааны тоогоор | 1 | 1 | Сумын дайчилгааны төлөвлөгөө, орон нутгийн төлөвлөгөөний ажлын хүрээнд техникийн 1 судалгаа гаргасан. | 1- 2 сард | 100 |
| 1.1.8 | **Арга хэмжээ 1.8.** Багийн хэмжээнд цэрэг татлагын ажлыг зохион байгуулах *(АБТодорхойлолт 1.4 дэх заалт)* | Иргэдийн хамрагдалтын хувиар | 98 | 100 | 2024 оны I ээлжийн цэрэг татлагад хамрагдах 18-25 насны 94 залуучууд бүртгэгдсэн. Эдгээрээс 5 сурагч, 14 оюутан, 51 энгийн иргэн, нийт 70 залуучууд цэрэг татлагад биеэр ирж хамрагдсан.<br>Цэрэг татлагад биеэр хамрагдаагүй 24 залуучуудаас гадаадад суралцаж байгаа 4, дотоод хэргийн их сургуульд суралцдаг 2, төгсөх курсын оюутан 3, тайван цагт цэргийн албанд үл тэнцэгчээр бүртгэгдсэн 3 иргэн, нийт 12 цэргийн насны залуучууд цэрэг татлагаас албан ёсоор чөлөөлөгдөж, оюутан цэргээр алба хааж байгаа 6, цэрэгжсэн байгууллагад ажиллаж байгаа 4 залуу бүртгэгдсэн. Зайлшгүй шалтгааны улмаас 2 залуу II ээлжийн цэрэг татлагад хамрагдах хүсэлт гаргасан.<br>2024 оны I ээлжийн цэрэг татлагад хамрагдсан 70 залуучуудаас цэргийн албанд тэнцэж Дотоодын цэргийн 05 дугаар ангид алба хааж байгаа 1, Хилийн цэргийн 131 дүгээр ангид алба хааж буй 3 залуу байна.<br>2024 оны II ээлжийн цэрэг татлагад 13 залуу хамрагдахаас 1 дүгээр курсын оюутан 4, гадаадад байгаа 1 залуу материалаа бүрдүүлж цэрэг татлагын комиссоор орохоос чөлөөлөгдсөн. 8 залуу комиссоор биеэр орж, 2 залуу цэргийн албанд тэнцэн Өвөрхангай | 4 - 11 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аймгийн 256 дугаар цэргийн ангид алба хааж байна.<br>2024 оны 1, 2 дугаар цэрэг татлагаас Арвайхээр сумын 7 дугаар багаас нийт 6 залуу цэргийн алба хааж байна. | | |
| | | Цэргийн алба хааж буй иргэдийн ар гэрт олгох дэмжлэг, туслалцаанд хамруулсан өрхийн тоогоор | - | Шаардлагатай өрхийг хамруулсан байдлаар | Хилийн цэргийн 131 дүгээр ангид алба хааж байгаа Ү.Дашчирэвийн ар гэрт малчны эрүүл мэндийн багц олгосон. Мөн тус цэргийн ангид алба хааж байгаа О.Нямхүү, О.Баярмагнай нарын ээж Г.Оюунчулууныг улирлын чанартай тогоочийн ажилд зуучилсан.<br>Дотоодын цэргийн 05 дугаар ангид алба хааж байгаа Ж.Ганзоригийн ээжийг түр ажлын байранд зуучлан хөдөлмөрт хамруулсан. | 4-12 сард | 100 |
| **ХОЁР. “Багийн өрх, хүн амын статистикийн мэдээллийг зохих журмын дагуу нийтэд мэдээлж, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж, удирдлагыг мэдээллээр хангах, тайлагнах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1.2.1 | **Арга хэмжээ 2.1.** Хүн ам, өрхийн мэдээллийн санг үнэн зөв хөтөлж, баяжилтыг тогтмол хийж, төрийн байгууллага, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажилласан байх *(АБТодорхойлолт 2.1 дэх заалт)* | ХАӨМС-ын программын алдааны тоогоор | - | Алдаагүй байх | 2024 оны байдлаар ХАӨМСанд иргэний нас баралттай холбоотой 16, шинэ төрсөн хүүхдийн мэдээлэл оруулахтай холбоотой 16 бүртгэл хийж, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 21 удаагийн хүсэлт шийдвэрлэж албан ёсоор шилжин ирсэн 93, шилжин явсан 103 иргэний бүртгэл мэдээлэлд тухай бүр баяжуулалт хийсэн. Мөн өрхийн болон хувь хүний үзүүлэлтийн алдаа, байршил тодорхойлоогүй өрхийн бүртгэлийг өдөр бүр хянаж, гарсан алдааг тухай бүрт засаж хэвшсэн. 2024.11.25-ны өдрийн байдлаар ХАӨМСанд бүртгэгдсэн алдаа байхгүй. | 1- 11 сард | 100 |
| 1.2.2 | **Арга хэмжээ 2.2.** Багт шинээр баригдсан орон сууцны тооллогын мэдээг ОС1, ОС3 | Шинээр баригдсан орон сууцны мэдээллийг маягтын дагуу | Шинээр баригдсан орон | Шинээр баригдсан орон | 2024 онд багт бүрэн баригдаж, ашиглалтад орсон 2 байшин байна. Дээрх 2 шинэ орон сууцны мэдээллийг маягтын дагуу гарган сумын Төсөв төрийн сангийн | 1- 11 сард | 100 |

147

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | маягтаар гаргаж өгөх *(АБТодорхойлолт 2.1 дэх заалт)* | гаргаж өгсөн тоогоор | сууцны тоогоор | сууцны тоогоор | мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. Үйлчилгээний зориулалттай 1 байр баригдаж байна. | | |
| 1.2.3 | **Арга хэмжээ 2.3.** Залуучуудын суурь судалгаанд баяжилт хийж шинэчилж гаргах (АБТодорхойлолт 2.3 дахь заалт) | Гаргасан судалгааны тоогоор | 1 | 1 | 2024 онд судалгааг сумын хэмжээнд нэгтгэн аваагүй. Багийн хэмжээнд 2024 онд 15-34 насны 789 залуучууд бүртгэлтэй байгаа бөгөөд багийн цахим бүртгэлд дээрх залуусын бүртгэлийг баяжуулж оруулсан. | 3 сард | 100 |
| 1.2.4 | **Арга хэмжээ 2.4.** Багт зохион байгуулсан ажил, арга хэмжээ болон бусад мэдээллийг олон нийтэд цахим хуудсанд сурталчлах *(АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1.2.1, АБТодорхойлолт 3.3 дахь заалт/*хамтран ажиллах гэрээний 1.2.1, АБТодорхойлолт 3.3 дахь заалт) | Багийн цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл боловсруулж иргэдэд нээлттэй сурталчилгаа хийсэн тоогоор | 6 | 6 | 2024 оны хагас жилд багийн 2100 гишүүнтэй 1 фэйсбүүк хаяг, 700 болон 500 гишүүнтэй 2 группээр дамжуулан зарлал мэдээлэл, эрүүл мэнд, багт зохион байгуулсан үйл ажиллагаа, бусад зэрэг 4 нэр төрлийн 70 орчим мэдээлэл, зорилтот жилтэй холбоотой 4 нэр төрлийн 21 удаагийн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 нэр төрлийн 41 удаагийн мэдээлэл тус тус цахимд оруулсан.<br>Мөн Газар хөдлөлтийн дадлага сургуулилтын талаар 1, БИНХуралтай холбоотой 2, Алдарт эхийн одон гардуулах тухай 1, ахмадын өдөрлөг зохион байгуулах тухай 1, нийт 5 постер бэлтгэж оруулсан. | 1- 11 сард | 100 |
| 1.2.5 | **Арга хэмжээ 2.5.** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн насны | Сургуулийн насны хүүхдийн хамран сургалтын хувиар | 100 | 100 | 2024 оны байдлаар багт сургуулийн насны 689 хүүхэд бүртгэлтэй байна. Эдгээрээс 1-р сургуульд суралцдаг 583, УБ хот болон бусад аймагт суралцаж байгаа 15, Арвайхээр сумын бусад сургуульд суралцаж байгаа 90 хүүхэд, гандан шавилан сууж | 9-12 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, хамран сургалтыг нэмэгдүүлэх, Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй иргэдийг дүйцсэн хөтөлбөрт хамруулж, боловсрол эзэмшүүлэх | | | | байгаа 1 хүүхэд тус тус бүртгэлтэй байна. Сургууль завсардсан 1 хүүхэд бүртгэлтэй. Сургууль завсардсан хүүхдийг сургуульд суралцуулах талаар эцэг эх болон сургуулийн нийгмийн ажилтантай хамтран ажиллаж сургуульд буцаан оруулахаар болсон. | | |
| | | Цэцэрлэгийн насны хүүхдийн хамран сургалтын хувиар | 93 | 95 | 2024 онд багт цэцэрлэгийн насны 173 хүүхэд бүртгэлтэй байгаагаас хамран сургах тойргийн 4 дүгээр цэцэрлэгт хамрагдаж байгаа 19, 6 дугаар цэцэрлэгт хамрагдаж байгаа 26, 5 дугаар цэцэрлэгт хамрагдаж байгаа 46, бусад цэцэрлэгт хамрагдаж байгаа 73, цэцэрлэгт хамрагдаагүй 9 хүүхэд бүртгэлтэй байна. Цэцэрлэгт хамрагдалтын хувь 94.8. | 9-12 сард | 99.8 |
| 1.2.6 | **Арга хэмжээ 2.6.** Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг явуулж 3-15кВт эх үүсвэрийн мэдээллийг программд бүрэн оруулах | Судалгааг шинэчилж, хугацаанд нь алдаагүй программд оруулсан хувиар | 100 | 100 | Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажлын хүрээнд багийн нутаг дэвсгэрт тогтмол оршин сууж байгаа ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай зуухтай 521 өрхийн судалгааг 35 үзүүлэлтээр гаргаж 2024.02.14-ний өдөр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвд явуулсан. Эдгээр 521 өрхөөс байшинд амьдардаг 259, гэрт амьдардаг 262 өрх байсан. Мөн эдгээр өрх жилд 1622 тонн нүүрс, 845 метр куб мод, 0.3 тонн сайжруулсан түлш хэрэглэсэн үзүүлэлттэй байсан. | 1- 2 сард | 100 |
| **ГУРАВ. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1.3.1 | **Арга хэмжээ 3.1.** Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргын үйл | Төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ажил байдлын тодорхойлолтод тусгагдсан албан үүрэг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сум орон нутаг, багт хэрэгжиж буй төрийн бусад үйл ажиллагааны | 1 сард | 100 |

149

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлуулах | | | | хөтөлбөрүүдтэй уялдуулан 2 бүлэг 28 зүйл заалтаар боловсруулан 1 дүгээр сарын 25-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газрын даргад уламжилсан. | | |
| 1.3.2 | **Арга хэмжээ 3.2.** Хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээ, албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэх, тэдгээрийг албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартын дагуу боловсруулах *(АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1.1.8, АБТодорхойлолт 4.3 дахь заалт)* | Тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн хувиар | 100 | 100 | 2024 онд түр орчин суугчтай холбоотой танхайрсан, архидан согтуурсан тухай зөрчлийн талаарх 4, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах тухай 1, үндсэн оршин суугчидтай холбоотой согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тухай 2, архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан тухай 3, нийт 10 мөрдөгчийн мэдэгдэл ирж, ГХЗУСТухай хуулийн 3.2т заасан үүргийнхээ хүрээнд тэдгээрийг ирсэн баримт бичгийн бүртгэлийн дэвтэрт бүртгэн авч, бүртгэл хяналтын карт хөтлөн багийн Засаг даргын хариу албан тоотоор мэдэгдлийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын илтгэх хуудас, судалгаа, мэдэгдэлд тэмдэглэсэн бусад шаардлагатай мэдээллийг хавсарган ЭХХШТухай хуулийн 29.6.2т заасан хугацаанд явуулсан. Жилийн эцсийн байдлаар хугацаа хэтэрсэн албан мэдэгдэл бүртгэгдээгүй. | 1- 11 сард | 100 |
| | | Албан бичгийн боловсруулалтад ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, | 100 | 100 | Багаас гарах албан тоотын боловсруулалтад зохион байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлагыг баримтлан MNS5140-2:2021 стандартыг мөрдөн 16 бүрдлийг, багийн Засаг даргын захирамжийн 10 бүрдлийг бүрэн бүрдүүлэн баримт бичгийг боловсруулж ажилласан.<br>Мөн албан тоотын хавсралтаар хүргүүлсэн захирамжлалын баримт бичиг | 1- 11 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Стандарт хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажилласан хувиар | | | болох удирдамж (12 бүрдэл), мэдээлэл лавлагааны баримт бичиг болох илтгэх хуудас (11 бүрдэл) зэргийг MNS5140-2:2021 стандартын бүрдлийг бүрэн хангаж боловсруулсан. | | |
| 1.3.3 | **Арга хэмжээ 3.3.** Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хугацаанд нь дээд шатны байгууллагад уламжилж, бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн байх, холбогдох мэдээ тайланг хугацаанд нь өгөх *(АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1.1.9, АБТодорхойлолт 4.3 дахь заалт)* | Алдарт эхийн одон, төрийн дээд одон медалиар шагнуулах иргэдийн материал, өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй уламжилж, хариу өгсөн хувиар | - | 100 | “Алдарт эх I” одонгоор шагнагдах 1 эх, “Алдарт эх II” одонгоор шагнагдах 9 эхийн өргөдлийг бүртгэж, одонгийн материал бүрдүүлэхэд шаардлагатай эхийн болон хүүхдүүдийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хүүхдийн эрүүл бойжиж байгаа тухай эмнэлгийн бичиг, багийн Засаг даргын тодорхойлолт зэрэг материалуудыг бүрэн бүрдүүлж сумын Засаг даргын Тамгын газарт илгээсэн. Дээрх 10 иргэн бүгд одонгоо бүрэн гардан авч, материал буцаагдсан тохиолдол гараагүй.<br>2024 онд төрийн дээд одон медалиар шагнуулах 7 иргэний материалыг Монгол улсын ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийн хавралтаар батлагдсан Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмын дагуу бүрдүүлж сумын ЗДТГазрын Соёл аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. Эдгээрээс Алтан гадас одонгоор шагнуулахаар уламжлах 1, Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтнаар шагнуулахаар уламжлах 2, | 1- 11 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулахаар уламжлах 3, "Соёлын гавъяат зүтгэлтэн" -д уламжлах 1 материал байсан. | | |
| | | Өргөдөл гомдлын мэдээг улирал тутам өгсөн тоогоор | - | 3 | I улирлын өргөдөл гомдлын мэдээний тайланг 2024.03.15-нд, II улирлын өргөдөл гомдлын мэдээний тайланг 2024.06.11-нд, III улирлын өргөдөл гомдлын мэдээний тайланг 2024.09.15-нд тус бүр гарган сумын архив бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгсөн. Нийт гаргасан тайлангийн тоо 3.<br>IV улирлын өргөдөл гомдлын мэдээний тайлант хугацаа болоогүй. | 1-11 сард | 100 |
| 1.3.4 | **Арга хэмжээ 3.4.** Аймаг, сумын удирдлагаас ирүүлсэн тогтоол, захирамжийг хяналтад авах, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах *(АБТодорхойлолт 4.3 дахь заалт)* | Тогтоол, захирамжийг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажилласан хувиар | - | 100 | Багийн иргэдийн Нийтийн хурлаас гарсан тогтоол 8, багийн ЗД-ын Тамга түшүүлэх тухай, Хамтарсан баг байгуулах тухай, Залуучуудын зөвлөл байгуулах тухай 3 захирамж, сумын ЗД-ын Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай, Архи согтууруулах ундаагаар үйлчлэхийг түр хориглох тухай 2 захирамжийг хяналтад авч бүртгэлжүүлсэн. БИНХурлаас гарсан тогтоолуудын биелэлтийг хангаж, хурлаас гарсан шийдвэрүүдийг тухай бүр сумын ИТХурлын ажлын албанд тайлагнасан. Сумын Засаг дарга болон багийн Засаг даргын дээрх захирамжийн биелэлтийг тухай бүр хэрэгжүүлсэн. | 1- 11 сард | 100 |
| | | "Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар *АЗДҮАХ-ийн 3.3.3.1 дэх заалт* | 50 | 100 | Хөтөлбөрийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 10 зүйл заалтаар боловсруулан I улиралд багийн Засаг даргаар батлуулж биелэлтийг ханган ажилласан. Биелэлт 93 хувьтай. | 1-11 сард | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.5 | **Арга хэмжээ 3.5.** Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомж, заавар журмын дагуу хөтлөн явуулж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтыг бүрдүүлж архивлах. *(АБТодорхойлолт 4.3 дахь заалт)* | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтыг бүрэн хөтлөх. Архивын баримтыг бүрэн бүрдэлтэй нь хугацаанд байгууллагын архивд хүлээлгэн өгсөн тоогоор | 5 | 6 | 2024 онд багийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар ирсэн бичиг, явсан бичиг, өргөдөл гомдол, тэдгээрийн бүртгэлийн дэвтэр, Малын А данс, Хүн амын өрхийн бүртгэлийн дэвтэр, "Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөр зэрэг 9 нэр төрлийн баримт бичгийг багийн Засаг даргаар батлуулсан.<br>2023 оны багийн хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтаар батлагдсан ирсэн бичиг, явсан бичиг, өргөдөл гомдол, багийн малчин болон мал бүхий 105 өрхийн малын А данс, "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" үндэсний хөтөлбөрийн биелэлт, хүн амын өрхийн бүртгэлийн дэвтэр зэрэг 6 нэр төрлийн баримт бичгийн бүрдлийг бүрэн хангаж дотоод товъёг болон архивт хүлээлгэн өгөх бүртгэлийн жагсаалтын хамт сумын архив бичиг хэргийн мэргэжилтэнд 2024.03.28-ны өдөр хүлээлгэн өгсөн. | 3 сард | 100 |
| | | Албан бичгийн стандартын дагуу боловсруулж, бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн байх | - | 100 | Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтаар батлагдсан 44 ирсэн бичиг, 61 удаагийн явсан бичиг, 13 өргөдөл гомдлын бүртгэлийг бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэлжүүлж, бүртгэл хяналтын карт хөтөлсөн. Мөн 10 удаагийн мэдэгдлийн хариу болон 2 удаагийн багийн иргэдийн Нийтийн хурлын материалууд дээр тусгай бүртгэл гарган хөтөлсөн. | 1- 11 сард | 100 |
| 1.3.6 | **Арга хэмжээ 3.6.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 50 | 100 | Багийн "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил"-ын төлөвлөгөөг I улиралд багтаан 5 бүлэг 18 зүйл заалтаар боловсруулан багийн Засаг даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль | 1- 11 сард | 96.5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | сурталчлах чиглэлээр 4 удаагийн танхимын сургалтаар 128 иргэнд, ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд зохион байгуулсан цахим халдлагаас сэргийлэх тухай, Хүүхэд хамгааллын хуулийн тухай мэдлэг олгох 2 удаагийн танхимын сургалтаар 233 сурагчдад мэдээлэл олгосон.<br>Мөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад Зам тээврийн ослоос сэргийлэх, цахим халдлагаас сэргийлэх, E-kids, “what3words” аппликейшнүүдийг сурталчлах чиглэлээр 2 удаагийн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж 97 хүүхэд хамруулсан.<br>Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх ажлын хүрээнд түр ажлын байранд 45, байнгын ажлын байранд 7 иргэн холбон зуучилсан.<br>Багийн цагдаатай хамтран сар бүр багийн нутаг дэвсгэрт эргүүл хяналтын ажил зохион байгуулж хэвшсэн. Мөн хөршийн холбооны ахлагчдаас сар бүр ажлын тайланг авч, тайланд тусгасан санал, гомдлыг хүлээн авч 15 удаагийн асуудал шийдвэрлэж, 6 асуудлыг дээд шатны байгууллагад уламжилж ажилласан.<br>Багийн хамтарсан баг 2024 онд нийт 6 удаа хуралдаж, хүүхдийн мөнгийг асран хамгаалагчийн данстай холбох тухай 1, хичээл завсардсан хүүхдийг сургуульд буцааж хамруулах тухай 1, хүүхэд үл хайхрах хүчирхийллийн тухай 2, нийт 4 асуудлыг шийдвэрлэж ажилласан.<br>Гэмт хэрэг зөрчилд холбогдох эрсдэлтэй иргэдийн судалгааг архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй, хүүхэд үл хайхрах хүчирхийлэл үйлддэг, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хорих ангид байгаа, хорихоос суллагдсан, хяналтад байгаа зэрэг 6 нэр төрлөөр ангилан гаргасан.<br>Хуулийн хүрээнд хориглолт хязгаарлалт тогтоолгосон 2 иргэн бүртгэлтэй байна.<br>Багийн цахим хаягуудаар дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай мэдээллийг иргэдэд тогтмол хүргэсэн.<br>Төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 96.5 | | |
| 1.3.7 | **Арга хэмжээ 3.7.** Аймаг, сумын зорилтот жилийн ажлын хүрээнд багт хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, үр дүнг тооцох | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 50 | 100 | "Цахим шилжилтийг эрчимжүүлэх" аймгийн зорилтот жилийн төлөвлөгөөг 3 бүлэг 13 зүйл заалтаар боловсруулан 1 дүгээр улиралд багийн Засаг даргаар батлуулсан.<br>Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөний хүрээнд EMongolia цахим системээр 29 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Багийн төвийн хурдан пос машинаар овог нэр солиулсан тухай лавлагаа 2, иргэний цахим үнэмлэхний лавлагаа 5 тус тус олгосон<br>Эрсдэлгүй Өвөрхангай аппликейшнийг сурталчлах ажлын хүрээнд тус аппликейшнийг ашиглах аргачлалын талаар гарын авлага бэлтгэн сургалт, нөлөөллийн ажлуудын үеэр нийт 230 ширхгийг тарааж, 150 орчим иргэний утсанд суулгаж өгсөн.<br>Wha3words аппликейшнийг сурталчлах ажлын хүрээнд гарын авлага бэлтгэн 250 ширхгийг тарааж, 150 орчим иргэний утсанд тус аппликейшнийг суулгаж өгсөн.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн саналыг цахимаар өгөх аргачлалын тухай багийн цахим хаягаар тогтмол сурталчилж, цэрэг татлагын үеэр иргэдийн утсанд ОНХС аппликейшнийг суулгаж, санал өгүүлсэн. | 1-12 сард | 83 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийт 31 иргэн ОНХСангийн саналыг цахимаар өгсөн.<br>E-Mongolia, What3words, Эрсдэлгүй Өвөрхангай, тоон гарын үсэг, ОНХС аппликейшнүүдийг ашиглах аргачлалын талаар 3 удаагийн танхимын сургалт, 1 удаагийн зөвлөгөө мэдээлэл олгох үйл ажиллагаа зохион байгуулж, 128 иргэнд мэдээлэл өгсөн. Хагас жилийн мал тооллогын үеэр What3words, Эрсдэлгүй Өвөрхангай, аппликейшний гарын авлагыг тус бүр 60 ширхгийг малчид, тариаланчдад тарааж, мэдээлэл олгосон.<br>Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд Хурдан төвтэй хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулж, 150 орчим иргэнд тоон гарын үсэг олгосон.<br>Цахим орчны соёлтой хэрэглээнд суралцах, цахим халдлагаас сэргийлэх тухай 2 удаагийн танхимын сургалтад 233 сурагчдыг хамруулж, wha3words аппликейшний зааварчилгааг танилцуулсан.<br>Зорилтот жилийн ажлын биелэлт 83 хувьтэй | | |
| 1.3.8 | **Арга хэмжээ 3.8.** Төрийн байгууллагын веб сайтад тавигдах мэдээг улирал бүр гарган, холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх, ажлын жагсаалтыг сар бүр хүргүүлэх | Веб сайтад байршуулах мэдээг гарган хүргүүлсэн тоо | - | 4 | Байгууллагын вэб сайтад байршуулах мэдээний I, II, III, IV улирлын тайланг гарган Арвайхээр сумын хэвлэл мэдээллийн ажилтан Болорцэцэгт цахимаар хүлээлгэн өгсөн. Гаргасан нийт тайлангийн тоо 4. | 1- 11 сард | 100 |
| | | Сар бүрийн ажлын жагсаалтыг хугацаанд нь хүргүүлсэн тоо | - | 11 | Багийн 1-11 сарын ажлын жагсаалтын тайланг сар бүрийн 25-ны дотор гарган ЗДТГазрын даргад хэвлэмэл хэлбэрээр, 1-4 сарын тайланг хууль эрхзүйн мэргэжилтэнд цахимаар хүлээлгэн өгсөн. Нийт 11 удаагийн тайлан өгсөн. 12 дугаар сарын тайлангийн хугацаа болоогүй. | 1- 11 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.9 | **Арга хэмжээ 3.9.** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байх | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй бүртгэгдээгүй ажилласан байх Зөрчлийн тоогоор | Ёс зүйн зөрчилгүй ажилласан байх | Ёс зүйн зөрчилгүй ажилласан байх | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил гаргасан тухай байгууллагын ёс зүйн хороонд бүртгэгдээгүй.<br>Харилцаа хандлага, ёс зүйн зөрчлийн талаар амаар болон бичгээр иргэдээс гомдол ирээгүй. | 1- 11 сард | 100 |
| 1.3.10 | **Арга хэмжээ 3.10.** Байгууллагаас зохион байгуулсан цаг үеийн холбогдолтой, нэмэлт үйл ажиллагаанд идэвхтэй оролцох. *(АБТодорхойлолт 3.4 дэх заалт)* | Оролцсон арга хэмжээний тоогоор | - | - | Байгууллагаас зохион байгуулсан 3 удаагийн олон нийтийн үйл ажиллагаа, 1 удаагийн баярын арга хэмжээ, 3 удаагийн сургалт, 2 удаагийн зохион байгуулалтын арга хэмжээнүүдэд тухай бүр бүрэн хамрагдсан. | 1- 11 сард | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт:**

| д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрсэн түвшин, биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ 1.** | Сонгуулийн хэсгийн хороонд ажиллах | - | 2024 оны УИХурлын сонгууль болон Орон нутгийн сонгуулиар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 7 дугаар тойргийн хэсгийн хороонд ажилласан. | - | 100 |
| 2 | | Арвайхээр сумын шуурхай штабд | - | 2024.03.10-нд сумын Шуурхай штабд 15 цагийн хугацаанд жижүүрийн үүрэг гүйцэтгэж, цаг | 2024.03.10 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 2.** | жижүүрийн үүрэг гүйцэтгэх | | үеийн ач холбогдолтой 3 судалгаа, 2 тайлан дээр ажилласан. | | |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.1 | **Арга хэмжээ 1.** | А3 сургалтад хамрагдах | - | Сертификат авсан байх | 2024 оны 3 дугаар сард Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдаж, шалгалт өгч тэнцэн сертификат авсан. | 1- 6 сард | 100 |
| 2.2 | **Арга хэмжээ 2.** | Компьютерийн өргөн хэрэглээний программ хангамж, цахим хөгжүүлэлт чиглэлээр 5-7 хоногийн хугацаатай танхимын сургалтад хамрагдах | - | Сургалтад хамрагдаж, мэдлэгээ сайжруулсан байх | Энгийн хэрэглээний компьютер дээр ашиглах боломжтой постер бэлтгэх, фотошоп хэрэглээний эх бэлтгэх “photoshop-2020” онлайн мастер сургалтад хамрагдаж эх бэлтгэл дээр ажиллах аргачлалд суралцсан. | 1- 12 сард | 100 |

ДЭЛГЭРЭХ ДЭНЖИЙН 7 ДУГААР БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

ТАЙЛАН ГАРГАСАН:

.............................. / А.НОРОВСҮРЭН /

2024.11.24